

Дорноговь аймаг дахь Политехник коллежийн
захирлын 2022 оны 02 дугаар сарын 25-ны
өдрийн 011 дугаар тушаалын 03 дугаар
хавсралт

БАГШ, АЖИЛТАН СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ 22010019

Нэг. Нийтлэг үндэслэл

Энэхүү журмаар Дорноговь аймаг дахь Политехник коллежийн (цаашид “Коллеж” гэх)-д ажилд орох иргэдийг сонгон шалгаруулах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулна. Хүний нөөцийг бүрдүүлэх, чадварлаг мэргэшсэн ажилтанг сонгон авч, ажиллуулах, байгууллагын үйл ажиллагааг чанаржуулахад оршино.

1.1. Багш, ажилтан сонгон шалгаруулах журам /цаашид журам гэх/ нь Монгол Улсын үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, сургуулийн дотоод журам болон холбогдох бусад хууль тогтоомж эрх зүйн актыг үндэслэл болгоно.

1.2. Сул байгаа орон тооны мэдээллийг байгууллагын цахим хуудас, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарлан, сонгон шалгаруулалтыг ил тод, шударгаар явуулна.

1.3. Тухайн сул ажлын байрны зар, тавигдах шалгуур, сонгон шалгаруулах журмыг сургуулийн dgamsut.edu.mn сайт бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэдэд нээлттэйгээр хүргэнэ.

Хоёр. Сонгон шалгаруулалтанд оролцогчдын бүрдүүлэх материал

2.1. Сонгон шалгаруулалтад оролцогч нь дараах баримт бичгийг бүрдүүлнэ.

2.1.1. Төрийн албан хаагчийн анкет

2.1.2. Ажилд орохыг хүссэн өргөдөл

2.1.3. Нийгмийн даатгалын лавлагаа

2.1.4. Ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт;

2.1.5. Иргэний үнэмлэхний хуулбар;

2.1.6. Мэргэжлийн үнэмлэх, дипломын хуулбар

2.1.7. Иргэний гурван үеийн намтар (эхнэр, нөхрийн 3 үеийн намтарын хамт)

2.1.8. Зураг 2 хувь /3x4/;

2.1.9. Эрүүл мэндийн үзлэгийн дэвтэр;

Гурав. Сонгон шалгаруулалтад оролцогчдын материалыг хүлээн авах

3.1. Сул орон тооны ажлын байрны зар олон нийтэд зарлагдсан хугацааны дотор энэхүү журмын 2.1-д заасан материалыг иргэдээс хүлээн авна.

3.2. Хугацаа хэтэрсэн материалыг хүлээж авахгүй.

3.3. Шаардлага хангаагүй материалыг оролцогчид буцаан олгож цаашдын сонгон шалгаруулалтад оролцуулахгүй.

Дөрөв. Сонгон шалгаруулалтын зохион байгуулалт

4.1. Сонгон шалгаруулах ажлын хэсэг нь захирлын дэргэдэх зөвлөл байна.

4.2. Ажилтныг сонгон шалгаруулахдаа зарлагдсан ажлын байрны тодорхойлолтод нийцүүлж, тухайн албан тушаалд сонгох бөгөөд багшлах боловсон хүчний хувьд энэ журмын 5 дугаар зүйлд заасан шаардлагын дагуу сонгон шалгаруулна.

ТАВ: Багшид тавигдах үндсэн шаардлага

5.1. Багш нь Монгол улсын үндсэн хууль, Боловсролын тухай, Дээд боловсролын тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль болон холбогдох эрх зүйн акт, тэдгээртэй нийцүүлэн гаргасан дээд шатны байгууллагын

шийдвэр, сургуулийн дүрэм журам, хичээлийн хөтөлбөр, стандартыг мөрддөг, сурталчилдаг, хөгжүүлдэг байх.

5.2.Суралцагчийн хандлага, төлөвшлийн тасралтгүй өсөлт, сургалтын орчин, нөөцөд тулгуурлан тодорхой үр дүнд хүргэх зорилгоор шинийг санаачлан хэрэгжүүлдэг, түүнд тогтмол хяналт тавьж сайжруулдаг байх.

5.3.Багш нь мэргэжлийн хувьд мэдлэг, дадлага, зөв хандлагатай, судалгааны ажлын арга зүй эзэмшсэн, заах арга зүй, сурган хүмүүжүүлэх мэдлэг, ур чадвараа дээшлүүлэхийн төлөө байнга суралцаж ажилладаг, ёс зүйтэй, багаар ажиллах, ярианы болон бичгийн өндөр чадвартай гадаад хэлийг зохих түвшинд эзэмшсэн хүн байна.

5.4.Багш нь сургалтын хөтөлбөрийг боловсруулахдаа шинэ мэдээлэл, техник, технологийг эрэлхийлэн тэдгээрийг дамжуулах биш суралцагчдын хэрэгцээнд тохируулан боловсруулж, хэрэгжүүлэх талаар бүтээлчээр сэтгэж ажилладаг байх.

Зургаа. Сонгон шалгаруулалтыг дүгнэх

6.1.Сонгон шалгаруулалтын дүнг оролцогчдод ил тод, нээлттэй мэдээлнэ.

6.2.Захирлын дэргэдэх зөвлөлийн шийдвэрийг үндэслэн шалгаруулалтад тэнцсэн иргэнтэй хөдөлмөрийн гэрээг байгуулна.

Сургуулийн захиргаа